

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/016-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх
Утас: 70363040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
Утас: 70363036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
Аудитор: Ж.Цогт
Утас: 70363047 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын ИТХ-ын “2025 оны тодотгосон төсөв батлах тухай” 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 32 дугаар тогтоолоор 1,042,818.7 мянган төгрөгийн татварын орлого, 330,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт 1,372,818.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,553,156.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 13.1 хувиар буюу 180,337.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын төсөв болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 10 төсөл, арга хэмжээнд 916,329.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 785,058.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 131,270.8 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шаамар сумын Засаг дарга нь тайлант онд 20 зорилт, 156 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,507,057.4	1,792,167.0
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	781,905.6	1,105,935.8
3	АВЛАГА	189,573.2	127,999.0
4	УРЬДЧИЛГАА	-	23,858.3
5	БАРАА МАТЕРИАЛ	535,578.6	534,375.8
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,050,402.3	7,758,496.9
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,050,402.3	7,758,496.9
8	Биет хөрөнгө	6,844,983.0	7,554,185.2
9	Биет бус хөрөнгө	205,419.3	204,311.7
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,557,459.7	9,550,665.8
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,121.3	33,102.3
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,121.3	33,102.3
13	Өглөг	1,121.3	33,102.3
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,556,338.3	9,517,563.5
15	Засгийн газрын хувь оролцоо	8,556,338.3	9,517,563.5
16	Засгийн газрын оруулсан капитал	693,139.5	693,139.5
17	Хуримтлагдсан үр дүн	6,293,341.1	7,254,566.3
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,569,857.8	1,569,857.8
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,557,459.8	9,550,665.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,307,817.7	4,535,476.6
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,036,798.9	1,145,034.8
3	Орлогын албан татвар	882,924.7	918,413.0
4	Хувь хүний орлогын албан татвар	945,809.8	985,272.3
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(62,885.0)	(66,859.4)
6	Хөрөнгийн албан татвар	44,527.8	60,739.1
7	Бусад татвар, төлбөр, хураамж	109,346.3	165,882.7
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,543,182.1	3,390,441.7
9	Тусламжийн орлого	-	1,613,403.9
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,727,836.7	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,173,517.8	3,074,562.0

12	УРСГАЛ ЗАРДАЛ	3,173,517.8	3,074,562.0
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,115,563.8	3,057,576.0
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,090,579.5	1,263,170.8
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,217.9	160,503.6
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	727,826.9	735,551.6
17	Хангамж, бараа материалын зардал	86,462.9	102,008.7
18	Эд хогшил, урсгал засварын зардал	91,825.2	82,863.2
19	Томилолт, зочны зардал	3,125.3	7,324.0
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	220,916.8	52,417.3
21	Бараа үйлчилгээний бусад зардал	755,609.1	653,736.8
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,954.0	16,986.0
23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,134,299.9	1,460,914.5
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	82,500.0	499,689.3
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(82,500.0)	(499,689.3)
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,051,799.9	961,225.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,504,538.4	7,504,538.4
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,504,538.4	7,504,538.4
3	Тайлант үеийн үр дүн	1,051,799.9	1,051,799.9
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,556,338.3	8,556,338.3
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,556,338.3	8,556,338.3
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,556,338.3	8,556,338.3
7	Тайлант үеийн үр дүн	961,225.2	961,225.2
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,517,563.5	9,517,563.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,188,831.9	3,591,313.5
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,036,798.9	1,145,034.8
3	Орлогын албан татвар	882,924.7	918,413.0
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(62,885.0)	(66,859.4)
5	Хөрөнгийн албан татвар	44,527.8	60,739.1
6	Бусад татвар, төлбөр, хураамж	109,346.3	165,882.7

7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	38,596.4	50,260.6
8	Газрын төлбөр	67,061.7	113,204.2
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,688.3	2,418.0
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	424,196.3	2,446,278.6
11	Нийтлэг татварын бус орлого	424,196.3	567,882.1
12	Тусламжийн орлого	-	1,613,403.9
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	264,992.6
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,727,836.7	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,392,907.3	2,486,827.5
16	УРСГАЛ ЗАРДАЛ	2,392,907.3	2,486,827.5
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,320,966.2	2,469,841.5
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,090,399.5	1,263,170.8
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,217.9	160,503.5
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	727,223.8	735,551.6
21	Хангамж, бараа материалын зардал	82,444.4	85,216.8
22	Нормативт зардал	-	220.0
23	Эд хогшил, урсгал засварын зардал	88,320.3	93,565.1
24	Томилолт, зочны зардал	3,125.3	7,324.0
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,861.8	59,953.8
26	Бараа үйлчилгээний бусад зардал	79,373.2	64,335.8
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,941.1	16,986.0
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	795,924.6	1,104,486.0
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	246,751.0	780,455.9
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	246,751.0	780,455.9
31	Дотоод эх үүсвэрээр	246,751.0	780,455.9
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(246,751.0)	(780,455.9)
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	85,764.1	-
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(85,764.1)	-
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	463,409.5	324,030.1
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	318,496.2	781,905.6
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	781,905.6	1,105,935.8

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,531,920.7	6,307,147.0	224,773.7	96.6
11	Татварын орлого	1,042,818.7	1,145,034.8	- 102,216.1	109.8
110	Орлогын албан татвар	884,377.5	918,413.0	- 34,035.5	103.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	946,377.5	985,272.3	- 38,894.8	104.1
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	730,977.5	810,068.0	- 79,090.5	110.8

110002	Үйл ажиллагааны орлого	26,300.0	38,444.3	-	12,144.3	146.2	
110003	Хөрөнгийн орлого	172,100.0	106,122.9	-	65,977.1	61.7	
110004	Хөрөнгө борлуулсны орлого	17,000.0	30,637.1	-	13,637.1	180.2	
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	62,000.0	-	66,859.4	4,859.4	107.8
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	62,000.0	-	66,859.4	4,859.4	107.8
113	Хөрөнгийн албан татвар	49,208.3	60,739.1	-	11,530.8	123.4	
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	7,836.3	14,480.6	-	6,644.3	184.8	
113002	Бууны албан татвар	668.0	390.0	-	278.0	58.4	
113004	Малд ногдуулах албан татвар	40,704.0	45,868.5	-	5,164.5	112.7	
118	Бусад татвар, төлбөр, хураамж	109,232.9	165,882.7	-	56,649.8	151.9	
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	37,468.3	50,260.5	-	12,792.2	134.1	
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	3,402.5	-	402.5	113.4	
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	19,468.3	38,579.0	-	19,110.7	198.2	
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,000.0	8,279.0	-	6,721.0	55.2	
1181	Газрын төлбөр	70,384.6	113,204.2	-	42,819.6	160.8	
118101	Газрын төлбөр	55,384.6	43,907.5	-	11,477.1	79.3	
118102	Дуудлага худалдаа	15,000.0	69,296.7	-	54,296.7	462.0	
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,380.0	2,418.0	-	1,038.0	175.2	
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	-	541.5	-	541.5	-	
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	380.0	-	-	380.0	-	
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,000.0	1,876.5	-	876.5	187.6	
12	Татварын бус орлого	5,489,102.0	5,162,112.2	-	326,989.8	94.0	
120	Нийтлэг татварын бус орлого	428,509.2	542,165.2	-	113,656.0	126.5	
120003	Торгуулийн орлого	300,000.0	376,661.3	-	76,661.3	125.6	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	98,509.2	134,043.6	-	35,534.4	136.1	
120009	Бусад орлого	30,000.0	31,460.3	-	1,460.3	104.9	
122	Тусламжийн орлого	4,795,600.2	4,354,954.4	-	440,645.8	90.8	
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,597,716.3	1,597,716.3	-	-	100.0	
122005	Төсвөөс санхүүжих	3,197,883.9	2,757,238.1	-	440,645.8	86.2	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	264,992.6	264,992.6	-	-	100.0	
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	264,992.6	264,992.6	-	-	100.0	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,887,282.0	3,254,150.7	-	633,131.3	83.7	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,907,770.1	2,475,644.7	-	432,125.4	85.1	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,804,698.0	2,458,658.7	-	346,039.3	87.7	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,413,151.3	1,263,170.8	-	149,980.5	89.4	
210101	Үндсэн цалин	664,824.7	639,450.0	-	25,374.7	96.2	
210102	Нэмэгдэл	663,814.2	573,075.4	-	90,738.8	86.3	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,179.6	-	-	9,179.6	-	
210104	Урамшуулал	75,332.8	50,645.5	-	24,687.3	67.2	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,877.7	160,503.5	-	25,374.2	86.3	
210201	Тэтгэврийн даатгал	126,266.0	108,655.4	-	17,610.6	86.1	
210202	Тэтгэмжийн даатгал	14,166.7	12,911.7	-	1,255.0	91.1	
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,331.3	9,118.6	-	2,212.7	80.5	
210204	Ажилгүйдлийн даатгал	5,781.0	4,399.8	-	1,381.2	76.1	
210205	Эрүүл мэндийн даатгал	28,332.7	25,418.0	-	2,914.7	89.7	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	795,824.5	735,551.6	-	60,272.9	92.4	
210301	Гэрэл, цахилгаан	164,665.2	118,480.1	-	46,185.1	72.0	
210302	Түлш, халаалт	605,777.7	604,201.3	-	1,576.4	99.7	
210303	Цэвэр, бохир ус	25,381.6	12,870.3	-	12,511.3	50.7	
2104	Хангамж, бараа материалын зардал	109,907.7	79,766.2	-	30,141.5	72.6	
210401	Бичиг хэрэг	18,384.2	7,810.4	-	10,573.8	42.5	
210402	Тээвэр, шатахуун	50,778.3	40,548.6	-	10,229.7	79.9	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,270.3	5,812.5	-	1,457.8	79.9	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,045.0	10,738.5	-	306.5	97.2	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,429.9	14,856.3	-	7,573.6	66.2	
2105	Нормативт зардал	2,024.0	220.0	-	1,804.0	10.9	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,024.0	220.0	-	1,804.0	10.9	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,118.9	95,515.0	-	41,603.9	69.7	
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,550.0	7,751.8	-	16,798.2	31.6	
210602	Тавилга	4,000.0	3,538.5	-	461.5	88.5	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	977.9	-	-	977.9	-	
210604	Урсгал засвар	107,591.0	84,224.7	-	23,366.3	78.3	
2107	Томилголт, зочны зардал	10,615.2	7,324.0	-	3,291.2	69.0	
210702	Дотоод албан томилолт	10,615.2	7,324.0	-	3,291.2	69.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,226.7	56,771.8	-	19,454.9	74.5	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,861.8	50,295.1	-	12,566.7	80.0	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	463.9	-	-	463.9	-	
210803	Даатгалын үйлчилгээ	1,767.7	813.6	-	954.1	46.0	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,531.9	490.4	-	1,041.5	32.0	

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	281.6	143.0	138.6	50.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,247.4	1,656.3	591.1	73.7
210807	Газрын төлбөр	6,505.0	3,263.3	3,241.7	50.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	567.4	110.0	457.4	19.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,952.0	59,835.8	14,116.2	80.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,876.7	47,937.1	11,939.6	80.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,075.3	11,898.6	2,176.7	84.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,072.1	16,986.0	86,086.1	16.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,072.1	16,986.0	86,086.1	16.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,740.0	12,870.0	12,870.0	50.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,032.1	100.0	66,932.1	0.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,300.0	4,016.0	6,284.0	39.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	880,329.5	778,506.0	101,823.5	88.4
220001	Барилга байгууламж	191,000.0	95,500.0	95,500.0	50.0
222001	Тоног төхөөрөмж	85,200.0	85,200.0	-	100.0
223001	Бусад хөрөнгө	604,129.5	597,806.0	6,323.5	99.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	99,182.4	-	99,182.4	-
230001	Эргэж төлөгдөх зээл	99,182.4	-	99,182.4	-
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,379,646.1	295,758.2	2,083,887.9	12.4
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 2,379,646.1	- 3,052,996.3	673,350.2	128.3
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 2,379,646.1	- 3,052,996.3	673,350.2	128.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	781,905.7	- 781,905.7	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,080,218.9	- 1,080,218.9	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	ТЗ цэвэр дүн
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	15,687.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,687.6
122	Тусламжийн орлого	15,687.6
1221	Хандив тусламж /дотоод/	15,687.6
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,687.6
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,049.9
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,412.7
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,225.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,132.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,132.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,132.6
2104	Хангамж, бараа материалын зардал	5,450.6
210402	Тээвэр, шатахуун	2,704.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,746.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,182.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,182.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,555.0
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 2,555.0
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 2,555.0

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагад ном хэвлэлийн зардал, дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байхад хяналт тавьж ажилласан,
- Албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж бичиг хэргийн зардлыг бууруулсан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 35 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад Шаамар сумын Дулаанхаан тосгоны Захирагчийн алба спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахад нийт **1,270.5** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8: байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зарлагыг тус бүр **1,221,520.5** мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд СТОУС-1: “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандарт болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **20,506.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,600.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 18,906.2 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **20,506.2** мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **11,229.0** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт:

1. Сумын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан “Бохир соруулах машин” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд “Монтир транс ХХК” нь 67,900.0 мянган төгрөгөөр шалгарсан боловч бичиг хэргийн ажилтны буруугаас шалтгаалан мөнгөн дүнг буруу тооцон, гэрээг 69,500.0 мянган төгрөгөөр байгуулан **1,600.0** мянган төгрөгийг гүйцэтгэгчид илүү шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 дахь “ Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. ЗДНХ-өөс холбогдох байгууллагын хүсэлт, шийдвэргүйгээр **10,560.3** мянган төгрөгийг дэмжлэг олгох, тэмцээн, уралдаан зохион байгуулахад зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.2 дахь “... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно”, 2.1.4 дэх “байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Сумын ИТХ нь өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгэгдээгүй **450.0** мянган төгрөгийн Си Ти Эс программын төлбөрийг тайлант оны төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.3 “бүх өр төлбөр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар нийт **6,625.4** мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зөрчил илэрлээ.

ЗДТГ: Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас бичиг хэргийн зардалд 1,879.0 мянган төгрөгийг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас шуудан, холбоо, интернэтийн төлбөрийн зардалд 817.0 мянган төгрөгийг,

ИТХ: Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас ИТХ-ын хуралдааны зардалд 3,929.4 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд буюу Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, 16 хөрөнгийг данс бүртгэлээс хасах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*”, УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн 13 (б)-д “*Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм*” ХЗУЗ-д “*... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнийг үнэлж, данс бүртгэлээс хасах хэрэгтэй...*” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	10,560.3			1	10,560.3	1	-				
ИТХ	2	4,379.4			2	4,379.4						
ЗАлба												
ЗДТГ	2	4,296.0	1	1,600.0	1	2,696.0						
Сумын ТТЗ-ийн дүн	6	19,235.7	1	1,600.0	4	17,635.7	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Төсвийн хөрөнгөөр тэмцээн зохион байгуулсан	1	1,270.5			1	1,270.5		
Нийт дүн	1	1,270.5			1	1,270.5		